

БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Б.НАРАНТУЯА

2017 оны ... сар ... өдөр

№ 2017 1 2 18 1 6 8

ЗАХИАЛГАТ СУРГАЛТ ЯВУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Энэхүү гэрээг богино хугацааны сургалтыг захиалгаар явуулах асуудлаар Эрүүл мэндийн хөгжлийн төв, түүнийг төлөөлж (цаашид Захиалагч гэх) Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн албаны дарга З.Наранбаатар, нөгөө талаас (цаашид Гүйцэтгэгч гэх) Багшийн хөгжлийн төв хариуцсан арга зүйч **Т.Сумъяасүрэн нар** нар 2017 оны... дугаар сарын ...-ны өдөр харилцан тохиролцож байгуулав.
- 1.2. Энэхүү гэрээ нь гэрээнд заасан захиалгат ажлыг гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 1.3. Гэрээг хоёр хувь үйлдсэн ба тус бүр адил хүчин төгөлдөр байна.
- 1.4. Гэрээ гурван хуудастай.

Хоёр. Захиалгат ажил, түүний нөхцөл

- 2.1. Энэхүү гэрээний дагуу ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс -2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр, нийт 24 мэргэжилтний **“Анагаах ухааны боловсрол судлал”**, сэдэвт богино хугацааны сургалтыг (цаашид Захиалгат сургалт гэх) АШУҮИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газрын Багш хөгжлийн төв (Гүйцэтгэгч)–д захиалав.

2.2.

№	Сургалтын сэдэв	Хүний тоо	Сургалтын цаг	Нэг суралцагчийн төлбөр	Нийт төлбөр
1	Анагаах ухааны боловсрол судлал	24	2 багц цаг	63000	3.024.000

Төлбөрийг хичээл эхлэхээс 3–5 хоногийн өмнө Захиалагч, Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийн дагуу захиалагч тал 100 хувь төлөх бөгөөд Гүйцэтгэгчийн бүрэн төлнө.

- 2.3. Захиалгат сургалт нь Захиалагч байгууллага дээр хичээллэнэ.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1. Захиалагч нь дор дурдсан эрх эдэлнэ. Үүнд:

- 3.1.1. Захиалгат сургалтыг сургалтын агуулга, төлөвлөгөө, холбогдох бусад журмын дагуу явуулж буй эсэхэд хяналт тавих, үнэлгээ өгөх, энэ асуудлаар Захиалагч, Гүйцэтгэгч талд шаардлага тавих, хариулт авах;
 - 3.1.2. Суралцагчдаас сургалтын төлөвлөгөө, холбогдох дүрэм, журмын дагуу амжилттай суралцахыг шаардах;
 - 3.1.3. Суралцагчдын сурлагын амжилт, суралцах үйл явцтай нь холбоотой бусад мэдээллийг Захиалагч, Гүйцэтгэгч талуудаас авах;
 - 3.1.4. Энэ гэрээг Захиалагч, Гүйцэтгэгч талуудтай хамтран дүгнэх, энэ асуудлаар өөрийн саналаа илэрхийлэх;
- 3.2. Захиалагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд:
- 3.2.1. Сургалт эхлэхэд сургалтын төлбөрийг Захиалагч, Гүйцэтгэгчийн төлбөрийн нэхэмжлэхийн дагуу бүрэн төлөх;
 - 3.2.2. Суралцагчдад суралцах хугацаанд нь сурах бололцоог хангах чиглэлээр зохих хэмжээний дэмжлэг туслалцаа үзүүлж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;
 - 3.2.3. Захиалагч байгууллагын ажлын байранд зохион байгуулах сургалтын анги танхим, техник хэрэгсэл, сургалтын орчинг бүрдүүлж бэлдсэн байх;
 - 3.2.4. Суралцагчидтай холбоотой зохион байгуулалтын ажлуудыг хариуцна. Үүнд:
 - 3.2.4.1 Суралцагчдад сургалт эхлэхээс өмнө сургалттай холбоотой мэдээллийг бүрэн өгөх;
 - 3.2.4.2 Сургалт эхлэхэд суралцагчдыг бэлэн байлгах, сургалтын явцад ирцийг хариуцах.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 4.1. Гүйцэтгэгч нь дор дурдсан эрх эдэлнэ. Үүнд:
 - 4.1.1. Захиалгат сургалтыг гэрээний дагуу зохион байгуулах, хяналт тавих;
 - 4.1.2. Суралцагчдад сурлагын амжилт, суралцах үйл явцтай нь холбоотой асуудлаар холбогдох хууль тогтоомж, сургалтын агуулга, төлөвлөгөө, болон бусад дүрэм, журмыг мөрдөхийг шаардах, биелэлтийг нь хангуулах;
 - 4.1.3 Суралцагч гэрээг зөрчсөн гэж үзвэл уг гэрээг цуцлах, сургалтаас хасах, энэ тухай Захиалагч талд мэдэгдэх;
 - 4.1.4. Энэхүү гэрээг талуудтай хамтран дүгнэх, энэ асуудлаар өөрийн саналаа илэрхийлэх;
- 4.2 Гүйцэтгэгч нь дор дурдсан үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 4.2.1. Захиалгат сургалтыг захиалгын дагуу, гэрээнд заасан хугацаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тасралтгүй чанартай явуулах;
 - 4.2.2. Суралцагчдад батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу мэдлэг чадвар олгох ажлыг зохион байгуулах, суралцагчдыг бүхий л сурах нөхцөлөөр хангах;
 - 4.2.3. Суралцагчдын сурлагын амжилт, суралцах үйл явцтай холбоотой асуудлаар захиалагчид тогтмол хугацаанд мэдээлэл хүргүүлж байх;

Тав. Бусад зүйл

- 5.1. Энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа талууд урьдчилан бичгээр мэдэгдэх ба асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 5.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас үүссэн хохирлыг үүргээ биелүүлээгүй тал бүрэн хариуцна.
- 5.3. Энэ гэрээтэй холбоотой асуудлаар талуудын хооронд үүссэн маргааныг аль болох харилцан ойлголцох зарчмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Харилцан ойлголцож чадаагүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Захиалагчийг төлөөлж:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ХӨГЖЛИЙН
АЛБАНЫ ДАРГА



З.НАРАНБААТАР

2017 оны ... -р сарын ... -ны өдөр

Гүйцэтгэгчийг төлөөлж:
СУРГАЛТЫН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ХАРИУЦСАН АРГА ЗҮЙЧ



Т.СУМЪЯАСҮРЭН

2017 оны 12-р сарын 19-ны өдөр